

## ЭРДЭНЭ РЕСУРСИЙН ХАР МОРЬ АЛТНЫ НЭЭЛТИЙН ХАЙГУУЛ БОЛОН БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ

---

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж, Канад Улс

2021.04.08

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь шинэ Хар Морь талбайн хайгуулын үйл ажиллагаа болон цаашдын хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөр, Баян Хөндий төслийн ажлын байрны чиглэл олгох сургалтыг эхлүүлсэн тухай, мөн Монгол Улс дахь коронавируст халдварын нөхцөл байдлын талаар мэдээлж байна.

**Онцлох мэдээлэл<sup>1</sup>** (Газрын зураг болон зураглалтай хавсралтаас танилцана уу):

- 2021 оны 1-р улиралд Хар Морь талбайд нийт 1,900 тууш метрийн 9 хайгуулын цооног өрөмдсөн.
  - Зорилтот бүсийн хойд хэсэгт өрөмдсөн AAD-65-аас AAD-67 цооногуудад хувирлын өргөн бүсүүдийг огтолж, хувирал үргэлжилж байгааг тодорхойлсон нь ирээдүйн өрөмдлөгийг чиглүүлнэ.
    - AAD-65 цооногт 113 метрээс эхлэн 1.15 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал;
    - AAD-66 цооногт 53 метрээс эхлэн 1.31 г/т алтны агуулга бүхий 14 метрийн интервал;
    - AAD-67 цооногт 110 метрээс эхлэн 0.32 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал огтолсон.
  - Хойд-урд структурын захын бүсүүдийг судалсан AAD-68 -73 цооногууд нь алт ба/болон хамсрах элементүүдийг огтолсон.
    - AAD-68 цооногт 192 метрээс эхлэн 1.41 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал;
    - AAD-70 цооногт 64 метрээс эхлэн 4.24 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон.
- 3-р улирлын эцсээр 2021 оны 2-р улирлын 3,000 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлсэн.
  - Тодорхойлох өрөмдлөгийг үндсэн трендийн дагуу цооног хооронд 100 метрийн зайтай өрөмдөхөөр төлөвлөсөн.
  - Ойролцоогоор 600 метрийн өрөмдлөгийг трендийн өмнөд тэлэлтийг шалгах аар төлөвлөсөн. (6 г/т алтны агуулга бүхий 45 метр интервал огтолсон AAD-58 цооногийн орчмын талбай багтана)

---

<sup>1</sup> Хэвлэлийн мэдээнд тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропийг тодорхойлох боломжтой

- Одоогоор ~1,100 тууш метрийн дээжийг лабораторид хүргүүлэн, үр дүнг хүлээж байна.
- Хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнө 4\*3 км-ийн талбайд геофизикийн загварчлал, гадаргын дээжлэлт, спектрийн судалгаа болон бусад судалгаануудыг хийж гүйцэтгэсэн.
  - Эдгээр судалгаанууд нь Хар Морь талбайн эрдэсжилтийн тухай бидний ойлголтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.
- Баян Хөндийн төсөл хөгжүүлэлтийн хүрээнд орон нутгийн иргэдэд зориулсан ажлын байрны чиглэл олгох сургалтыг төслийн талбайд хэрэгжүүлж эхэлсэн.
  - Хоёр ээлжийн 36 иргэдэд Эрдэнэ Ресурсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, олон нийттэй харилцах баг сургалт хийсэн.
  - Цаашдын сургалтуудад оролцохоор 140 иргэн бүртгүүлээд байна.
- 3 сарын 24-нд Баянхонгор аймагт Ковид-19 вирусний анхны тохиолдол бүртгэгдсэн
  - Орон нутгийн засаг захиргаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.
  - Эрдэнэ Ресурс нь Аймгийн Онцгой Комиссд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.
  - Хар Морь талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийг халдвар хамгааллын өндөр шаардлагын доор үргэлжлүүлж байна.

### Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “2021 оны 1-р сард танилцуулсан Хар Морь алтны нээлтээс хойш манай техникийн баг өнгөрсөн улирлын турш хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. 1-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр 1.2 км хойд-урд тренд структурын дагуу алтны эрдэсжилтийн систем үргэлж байгааг баталгаажуулж, Баян Хөндий орд болон алтны эрдэсжилт, гидротермаль хувирлын системийг агуулж байгаа гэж үздэг Улаан-Хөндийн өргөн хувирлын системтэй холбоотой тогтоц болон нээлтийн тухай ойлголтоо нарийвчилж чадлаа.”

“3-р сарын сүүлчээр бид Хар Морь талбайн нээлтийн бүсэд 3,000 метрийн гүехэн, тодорхойлох өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь хэдийгээр Хар Морь структурын хойд хэсэгт төвлөрөх боловч судлын дагуу туушдаа 2.5 км газрыг хамарна. Дээжлэлтийн эхний хэсгийг лабораторид хүргүүлсэн бөгөөд ирэх долоо хоногуудад үр дүнг танилцуулахаар төлөвлөж байна.”

“Манай хээрийн ажил үргэлжилж байх хугацаанд Монгол Улсад Ковид-19 вирусний тархалт нэмэгдэн, төсөл байршдаг Баянхонгор аймагт халдварын тохиолдлууд бүртгэгдлээ. Бид аюулгүй ажлын байр, халдваргүй орчныг бүрдүүлэх зорилгоор боломжит бүх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн орон нутгийн халдвар хамгааллын үйл ажиллагаанд тусламж үзүүлэх зорилгоор аймгийн онцгой комиссд яаралтай тусламж хандивласан. Монгол Улс дахь Ковид-19 халдварын нөхцөл байдал нь Баян Хөндий алтны төслийн барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд үзүүлэх нөлөөллийг анхааралтай ажиглаж байна.” хэмээн танилцууллаа.

## **2021 оны 1-р улиралд Хар Морь талбайд хийсэн хайгуулын ажлын тойм**

Эрдэнэ Ресурс 2021 оны 1-р улиралд Хар Морь талбайд дараах хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэв:

- Нийт 1900 тууш метр, 9 цооног өрөмдсөн бөгөөд өрөмдлөгийг Фалкон Дриллинг (Falcon Drilling) компани гүйцэтгэсэн;
- Нарийвчилсан гадаргын зураглал болон дээжлэлтийг гүйцэтгэсэн;
- Геофизикийн загвар болон тайллыг Вэйв Геофизикс (Wave Geophysics, Denver Colorado)-ийн тусламжтайгаар гүйцэтгэсэн;
- Гадаргын болон цооногийн спектрийн хувирлын судалгаа болон тайллыг Плас Минералс (Plus Minerals, Ulaanbaatar) гүйцэтгэсэн;
- Эрдэжилт болон петрографийн судалгаа болон тайллыг Аспар Геосайнс (Aspar Geoscience, New Zealand) ашигласан;
- АЛС Лаборатори анхан шатны металлургийн судалгааг хийсэн (ALS Laboratories, Ulaanbaatar)
- Хөндий хувирлын систем дэх Хар Морь талбайн эрдэсжсэн системийн эх үүсвэр, шинж чанарын талаар Др. Жеффри Хэдэнгист (Dr. Jeffrey Hedengvist)-тай хамтран ажиллаж байна.

Хайгуулын болон судалгааны ажлууд нь шинэ Хар Морь нээлтийн геологийн шинж чанарыг тодорхойлох, түүнтэй ойр орших Баян Хөндий эпитеpmаль алтны орд болон Улаан-Хөндийн кварц-серицит-пиритийн хувирлын геологийн тогтцын тухай ойлголтыг сайжруулах ач холбогдолтой. Дэлхийн томоохон эпитеpmаль алтны ордуудад ажиглагддаг өргөн тархсан эрдэсжсэн гидротермалийн систем болохыг хайгуулын үр дүнгүүд нотолсоор байна. Хар Морь талбайн структур нь Баян Хөндий алтны ордтой холбоотой бөгөөд 4 км-ийн турш урд хойд трендийн дагуу тэлэлтийн бүсээр холбогдож байна.

### **Өрөмдлөгийн үр дүнгүүд – 2021 оны 1-р улирал**

2021 оны 1-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийг тодорхойлсон бүсийн ойр орчмын талбайн геологийн мэдээллийг нэгтгэх, ирээдүйд хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлох зорилгоор гүйцэтгэсэн.

2021 оны 2-р сард компани нь Хар Морь талбайд 1,900 тууш метрийн 9 цооног өрөмдсөн. Хар Морь талбайн хойд хэсэгт 1.2 км-ийн турш AAD-65-67 гурван цооног өрөмдсөн. Үлдсэн цооногуудыг трендийн дагуу өрөмдөн, AAD-71 цооногийг гол структураас урд зүгт 1 км-т AAD-58 цооногийн ойролцоо өрөмдсөн.

Доорх хүснэгт 1-т өрөмдлөгийн үр дүнгн онцлох мэдээллийг танилцуулав.

**Хүснэгт 1 – Хар Морь өрөмдлөгийн онцлох мэдээлэл**

	Цооног	(м)-ээс	(м) хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т Алт <sup>(2)</sup>
Хойд-Урд структурын дагуу	AAD-65 <sup>(4)</sup>	113	120	7	1.15
	Ба	128	142	14	0.51
	Ба	196	205	9	0.69
	AAD-66 <sup>(4)</sup>	53	67	14	1.31
	Ба	112	132	20	1.74
	Ба	137	139	2	0.96
	AAD-67 <sup>(4)</sup>	110	116	6	0.32
Захын бүсүүд	AAD-68	192	194	2	1.41
	Ба	250	252	2	0.47
	AAD-70	52	53	1	0.66
	Ба	64	66	2	4.24
	ба	110	116	6	0.33

<sup>1</sup> Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Хар Морь талбайд эрдэсжсэн бүсийн чиглэлийг тодорхойлох хангалттай өрөмдлөг хийгдээгүй тул одоогоор бодит зузааныг тодорхойлох боломжгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногууд нь (зөв өнцгөөр) 45-75 градусын уналтаар энгийнээс боломжит эрдэсжсэн талбайн трендийн дагуу өрөмдсөн

<sup>2</sup> Тайлагнасан интервалын агуулга нь дунджаар 1-2 метр интервалын дээжид тулгуурласан жигнэсэн дундаж агуулга болно. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Тэмдэглэл: AAD-69, AAD-71, AAD-72 ба AAD-73 цооногуудад аномаль алт ба/эсвэл хамсрах элементүүд (As, Mo, Sb) огтолсон боловч 0.3 г/т алтны агуулгаас өндөр интервал огтлоогүй.

Хар Морь талбайн хойд хэсэгт гурван цооног (AAD-65, AAD-66 ба AAD-67) өрөмдсөн. Өнгөрсөн хөтөлбөрөөр танилцуулсан AAD-61 (0.5 г/т алт бүхий 130м) цооногоос 290 болон 160 метр хойд, зүүн хойд зүгт AAD-65 болон 66 цооногуудыг байршуулсан. Эдгээр цооногуудаар хэд хэдэн алт агуулсан бүсүүдийг огтолсон, үүнд AAD-66 цооногт 1.3 г/т алтны агуулга бүхий 14 метр, 1.7 г/т алтны агуулга бүхий 20 метр интервалууд, AAD-65 цооногт 59 г/т мөнгөний агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон. Энэхүү хоёр цооногийн эрдэсжилт нь гематит, лимонит, гетитийн исэлдэл бүхий хувирсан өргөн шаварлаг болон брекчийн галт уулын чулуулагт агуулагдаж байна. AAD-61 цооногоос өмнө зүгт 260 метрт AAD-67 цооногийг өрөмдсөн нь гидротермаль брекчийн галт уулын цуварсан болон давамгайлсан хувирал бүхий нарийн аномаль алтны бүсүүдэд өргөн интервал огтолсон. Гурван цооногоор структураар хянагдсан эпитеpmаль системд тогтмол тохиолддог хавчиг, хөөсөн хэв маягтай шингэн урсгал үүсэх тааламжтай бүсийг бий болгон, Хар Морь талбайн структурын урд хойд судлын дагуу эрдэсжилт үргэлжилж байгааг баталгаажууллаа.

Хойд-урд структурт 1.2 км талбайд өргөн зайтай арван цооног өрөмдсөн. Өрөмдсөн цооногуудын хоорондох зай нь дунджаар 160 метр (42 метрээс 255 метр) бөгөөд дундаж гүн нь 155 метр, хамгийн гүн цооног нь 242 метрт (AAD-57) өрөмдсөнөөр цооногоос 100 метрийн гүнд алтны хүчтэй эрдэсжилт байгааг тодорхойлсон. 2021 оны 1-р улиралд өрөмдсөн өрөмдлөг нь Хар Морь талбайн хойд хэсэгт (AAD-57 цооногийн хойд) төвлөрсөн нь энэхүү өрөмдлөгөөр өмнө өрөмдсөн Хар Морийн структурыг агуулагч нээлтийн цооног AAD-58 (6г/т алт бүхий 45 м) болон AAD-57

(1.2 г/т алт бүхий 45м) цооногийн багтсан талбайд цооног хоорондын зайг ойртуулан өрөмдөхөд чиглэсэн.

Хар Морийн голлох, урд хойд структураас гадна өрөмдсөн цооногуудаар Хар Морийн хэтийн төлөв бүхий ерөнхий талбайн геохимийн хөрсний аномаль болон геофизикийн шинж чанарыг ойлгоход чиглэсэн. Эдгээр цооногууд нь аномаль алтны эрдэсжилттэй уялдан өргөн тархсан гидротермаль хувирал болон голлох хамсрах элементүүдтэй аномаль бүхий Хар Морь талбайд гол структурын хүрээг тэлэх шинэ боломжуудыг тодорхойллоо. Аномаль алтны эрдэсжилтийн өргөн тархсан бүсүүд нь үндсэн хамсрах элементийн аномализм, гидротермалийн хувирал, цахиуржилт болон галт уулын хэлтэрхийн брекчсэн геологи нь Хар Морь талбай нь томоохон эрдэсжилтийг агуулах боломжтой орчин гэдгийг илтгэж байна. Дээрх ойлголтуудыг цаашдын өрөмдлөгөөр шалгана.

### Өрөмдлөгийн хөтөлбөр – 2021 оны 2-р улирал

Эхний 1,110 тууш метр өрөмдлөгийн дээж нь Улаанбаатар хот дахь Эс Жи Эс Лабораторид хүргэгдсэн. Сорьцлолтын үр дүнгүүдийг ирэх долоо хоногуудад танилцуулна.

### Геофизикийн загварчлал ба тайлал

Хар Морь талбайн 2D, 3D геофизикийн загварчлал нь чиглэл тодорхойлох болон структурын шугаман зураглалын чухал хэрэгсэл юм. Соронзон зураглалаар нам соронзон шинж чанар болон аномаль алтны эрдэсжилтийг агуулагч магнетит эвдрэл бүхий шавран хувирлын бүсүүдтэй холбогдож байгааг илрүүлсэн. Өдөөгдсөн туйлшрал (IP) нь Хар Морь талбайд ирээдүйд тодорхойлох хэрэгсэл болох боломжтой бөгөөд өрмийн дээжид ажиглагдсан тархалт бүхий сульфид нь аномаль алтны интервалтай давхацдаг.

Геофизикийн загварчлал, тайлал болон тодорхойлолтын ажлууд хийгдэж байгаа нь Хар Морь системийг дэлгэрэнгүй ойлгоход чухал ач холбогдолтой. Хайгуулын амжилтуудыг үр дүнтэй байлгах зорилгоор 2021 оны хээрийн ажлуудын үеэр геофизикийн судалгааг үргэлжлүүлэн хийнэ.

### Шавран хувирал болон богино долгионы хэт улаан туяаны шинжилгээ (SWIR)

Смектит (Баян Хөндийд ховор тохиолддог), иллит (Баян Хөндийд давамгайлдаг), мөн каолинит агуулсан бага температур бүхий аргиллын шаврын давхарга, Хар Морь талбайн эрдэсжилт нь газрын дөт гүн дэх (150 метр) эпитеpmаль системтэй холбоотой гэж үзэж байна. Баян Хөндийтэй төстэй Хар Морь нь иллитийн шавран хувирал давамгайлсан. Хар Морь дахь бага температур бүхий аргиллын шавар давхарга нь эпитеpmаль системийн дээд үе давхаргын зураглалын (150 метрээс бага) үүслийг илэрхийлдэг. Баян Хөндийд энэхүү шавран эрдэс ажиглагддаггүйг энэхүү давхарга нь 150 метрээс гүнд үүсэж бий болсон хэмээн тайлсан. Хэрвээ Хар Морь нь гидротермал системийн дээд хэсгийг илэрхийлж байгаа бол өндөр агуулга

бүхий эрдэсжилт нь гүндээ байх боломжтой. Энэхүү онол нь газрын дөт гүн дэх литокапын бүсийг илэрхийлэх магадлалтай AAD-57 ба AAD-58 цооногийн ойролцоо нүхэжсэн/ үлдэгдэл цахиурын биетээр батлагдаж байна.

### Гажилт агуулсан эпитеpmаль загварчлал

Зүүн хойд ба баруун хойд трендийг зүссэн структур ба хуваагдлуудын огтлол болох хэд хэдэн бүс болон Хар Морь талбайн урд хойд структурын шинж чанар нь соронзон судалгааны зураг дээр хамгийн тод тодорхойлогддог (Хавсралт дахь зурагтай танилцана уу). Өнөөгийн структурын тайллаар Хойд-Өмнөд (N-S) тренд структур нь баруун ба баруун өмнөд зүгээс тектоник шахалтаас үүссэн тэлэлтийн бүсийг илэрхийлж байна гэж үзэж байна (Klorpenburg, 2017). Үр дүнд нь гидротермал шингэнийн дамжуулалт болон дараалсан хувирал болон эрдэсжилтийг тэлэлтийн бүсүүдийг бий болгосон. Талбайн структурын бүтцийг үргэлжлүүлэн судалж, ойлгосноор Хөндий дүүрэг дэх Хар Морийн эрдэсжсэн бүсүүдийг үргэлжлүүлэн тодорхойлоход чухал ач холбогдолтой.

### Баян Хөндий Алтны Төслийн ажлын байрны чиглэл олгох сургалт

2020 оны эцэст Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд цуврал сургалтууд болон олон нийтэд чиглэсэн хөтөлбөрүүдийг боловсруулж эхэлсэн. Эдгээр хөтөлбөрүүдэд компанийн ажлын байрны чиглэл олгох сургалт, тэтгэлэгт хөтөлбөрүүд, мэргэжлийн сургалтууд багтсан бөгөөд эдгээр нь аймаг, орон нутгийн иргэд рүү чиглэсэн. 2021 оны 3-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий төслийн талбайд орон нутгийн иргэдтэй хамтран ажлын байрны чиглэл олгох сургалтыг зохион байгуулсан. Эрдэнэ Ресурсийн Монгол дахь удирдлагын болон ХАББООНХ (HSEC)-ны багийн удирдлага дор орон нутгийн иргэд таван өдрийн турш уурхайн хөгжүүлэлт, эрүүл мэнд аюулгүй байдал болон байгаль орчны удирдлага, орон нутгийн оролцогч талуудын хамтын ажиллагааны сэдвүүдээр ганцаарчилсан болон багийн хамтарсан сургалтуудад хамрагдсан. Одоогийн байдлаар нийт 36 хүн энэхүү сургалтад хамрагдсан ба сургалтын үр дүнд санал болгож буй уурхайн олборлолттой холбоотой хувийн хөгжлийн төлөвлөгөөг тодорхойллоо. Иргэд энэхүү хөтөлбөрт маш идэвхтэй оролцсон тул компани нь Ковид-19 вирусний тархалтын нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр хөтөлбөрөө дахин хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Эрдэнэ Ресурс нь төслийн бүтээн байгуулалтын үе шатанд дунджаар 500 гаруй шууд ажлын байр, төслийн оргил үед 400 орчим иргэдийг ажлын байраар хангах төсөөлөлтэй байна. Баян Хөндий алтны төсөл нь Баянхонгор аймаг дахь хамгийн том ажил олгогч болж, уурхайн ашиглалтын хугацаанд Монгол Улсын төсөвт орлогын албан татвар, АМНАТ зэрэг хэлбэрээр 100 сая ам.долларыг төвлөрүүлэхээр төлөвлөж байна.



## Монгол Улс дахь Ковид-19 нөхцөл байдал

2020 оны 11 сард Ковид-19 вирусний халдвар голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар дотоодын хөл хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний салбарт хязгаарлалт хийсэн. Хэдийгээр 2021 оны 1-р улиралд хөл хориог сулруулсан боловч Улаанбаатар хотод бизнесийн болон олон нийтийн үйл ажиллагаа хэвийн явуулахад хязгаарлалттай хэвээр байв. 2021 оны 3 сард Эрдэнэ Ресурсийн төслүүд оршдог Баянхонгор аймагт халдвар илэрснээр аймагт нэвтрэх болон гарах хөл хөдөлгөөнийг хязгаарласан. Эрдэнэ Ресурс нь Баянхонгор аймгийн Онцгой Комиссд аймаг дахь Ковид-19 тархалтыг хязгаарлах зорилгоор яаралтай санхүүжилтийн тусламж үзүүлсэн.

Эрдэнэ Ресурс нь 2020 оны дунд үеэс эхлэн ажилтнуудын аюулгүй байдал, бүтээмжийг анхаарч, үйл ажиллагааны зохицуулалтыг хийсэн. Хээрийн кэмп дээр ажилтнуудын эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хүрээнд өдөр тутмын зааварчилга өгч, биеийн температур шалгах, эрүүл ахуйн сайжруулсан протоколыг мөрдөн, түргэвчилсэн оношлуур ашиглах болон бусад хувийн хамгаалах хэрэгслийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Мөн компани нь Ковид-19 тест хийх чадвартай, мэргэжлийн сувилалчийг ажиллуулж байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр манай баг 2021 оны 1-р улирлын Хар Морь талбайн хайгуулын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, 3-р сард дараагийн хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Компанийн захиргааны баг нь ажлын хуваарьт үргэлжлүүлэн өөрчлөлтүүдийг оруулан, үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, эрүүл ахуйн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ковид-19 вирусний Компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл өнөөг хүртэл бага байсан боловч халдварын цар хүрээ улам өргөжиж байна. Компани нь 2021 оны 2-р хагаст барилгын бүтээн байгуулалтын шийдвэрийг гаргахаас өмнө Ковид-19 цар тахлын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, Баян Хөндий алтны төслийн хуваарь, төсөвт гарч болзошгүй саад бэрхшээлийг судалж байна.

COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэхэд бие сэтгэлээ зориулж буй эрүүл мэндийн ажилтан албан хаагчид, цагдаа, тусгай үүргийн албан хаагч нарт компанийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

## Хөндий Алтны Дүүргийн Тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц<sup>2</sup> (“Measured and Indicated Resources”) <sup>3</sup>, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Мэргэшсэн этгээд (геологч) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш

<sup>2</sup> Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43- 101 техникийн тайлангаас танилцана уу.

<sup>3</sup> Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц



агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>



# KHUNDII GOLD DISTRICT

Three Priority Areas For Growth on 100% owned 17,000 ha Licence Holdings


Landsat 8 True Colour






# NEW DARK HORSE GOLD PROJECT

## Mineralized Structural Corridor



GEOEYE Satellite Image



Magnetics RTP Tilt Derivative




# DARK HORSE DISCOVERY 2021

## Q1-Q2 Planned and Completed Drilling

OPEN


1.2 km

OPEN



Phase 1 DDH Trace  
IN-PROGRESS

Phase 1 DDH Trace  
COMPLETED  
Results Pending



A'

Dark Horse Section

A

Q1 2021 Scout Hole

Q4 2020 Discovery Hole

● Drill Collar


Gold Grade Shells

Light Green	0.1
Yellow-Green	0.2
Orange	0.5
Pink	≥ 1.0

500m

# DARK HORSE LONG SECTION

Looking West (Gold in Drill Intersections on 3D Magnetics)





# DARK HORSE DISCOVERY SECTIONS

Looking North (each section 250m wide)

